

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН 2019 ОНД БАЙГУУЛСАН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2019.12.23

Хэрэгжүүлэх арга хэмжээ (ямар бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ)	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг хэмжих шалгуур үзүүлэлт (тоо, хувь, чанар)	Тухайн жилийн хүрэх түвшин	Хэрэгжит	Хувь
1	2	3	4	5
<p>1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.23 дахь заалт, ХХААХҮС-ын 45 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 538 дугаар захирамжийг хэрэгжүүлэх</p>	<p>Хүн амын эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлнэ.</p>	<p>Ажлын төлөвлөгөөг 95%-тай хэрэгжүүлнэ.</p>	<p>Мах сүүний анхдугаар аяны 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг газрын даргаар батлуулан 91.3%-тай хэрэгжүүллээ. Аймгийн хэмжээнд сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах 2 цех үйл ажиллагаа явуулж 11-р сарын байдлаар 18 мянган литр сүүн бүтээгдэхүүн боловсруулж хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн байна. ЖДҮХСангийн хөнгөлөлттэй зээлээс 70 сая төгрөгийг мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах 1 иргэний төсөлд, СХСангаас Эрдэнэдалай, Сайнцагаан, Цагаандэлгэр сумдад мах, сүүний чиглэлийн үхрийн фермер, мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр цех байгуулах 2 иргэн, 3 ААНэгж, Баянжаргалан, Өлзийт, Луус сумдад ингэний сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах цех байгуулах 4 иргэний төсөлд нийт 219,3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж 16 ажлын байрын тоо нэмэгдэж 0,5тн бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ. Аймгийн Засаг даргын Тамгын газраас Ноён Шанхай ХХК-ны хоногт 300 бог, 50-80 бод мал төхөөрч, мах,</p>	<p>100</p>

			<p>махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах 1 га газрын асуудлыг шийдэж өгсөн. Дээрх үйлдвэр нь нийт 6.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээс Чех улсаас 4,5 тэрбум, өөрийн 2 тэрбум төгрөгийн хөрөнгийг гаргахаар ажиллаж байна.</p> <p>Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл нь Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Сайнцагаан, Дэлгэрцогт сумын сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нийт 50 иргэнд технологийн чадваржуулах сургалтыг зохион байгуулж зах зээлийн хөгжил хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэдалай сумын Содбриллант, Дэлгэрцогт сумын “Номын өргөө” ХХК-иудын үнээний ферм, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн тус бүр 50,0 сая төгрөгийн төслүүд дэмжигдэн судлагдаж байна.</p> <p>2019 оны байдлаар Дундговь аймгийн төвд уламжлалт аргаар мах бэлтгэх 2 цэг ажиллаж нийт 54 мян.толгой мал нядалж зах зээлд нийлүүлсэн байна. Одоогийн байдлаар Стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан агуулахад 97 тн нөөцөлсөн нь 2020 оны хавар зах зээлийн ханшаас 500-1000 төгрөгөөр хямд махыг иргэдэд худалдаалах боломжийг бүрдүүллээ.</p> <p>Мал эмнэлгийн ерөнхий газрын 2019 оны 01/1046 тоот албан бичиг , Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу Улаанбаатар хотод Эрдэнэдалай, Адаацаг, Дэрэн, Сайнцагаан, Хулд, Сайхан-Овоо, Дэлгэрцогт сумдын малчид 128,0 тонн хонь, үхрийн махыг зах зээлийн</p>	
--	--	--	--	--

			<p>бөөний үнээс дээш, жижиглэнгийн үнээс хямд өртөгөөр худалдан борлууллаа.</p> <p>Мөн 12 дугаар сарын 05-08 ны өдрүүдэд төв суурин газрын хүн амын махны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор “Өвлийн идэш” махны өргөтгөсөн худалдааг Улаанбаатар хотод 21 аймгийн анхдагч болж зохион байгууллаа. Тус худалдааны үеэр үзлэг шинжилгээнд хамрагдсан, гарал үүсэл нь тодорхой уламжлалт аргаар бэлтгэсэн мах, малын дайвар бүтээгдэхүүнийг 117,4 тн махыг зах зээлийн үнээс 1500-2000 төгрөгийн хямд үнээр малчид өөрсдөө нийслэлийн иргэдийн хүнсний хэрэгцээнд нийлүүлээд байна.</p>	
2. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 4.2.5-ыг хэрэгжүүлж ажиллах	Аймгийн аварга тогооч шалгаруулах ур чадварын уралдаан зохион байгуулах	Үндэсний болон орон нутгийн онцлог бүхий хоол ундааг түгээн дэлгэрүүлэх үүднээс “Аймгийн аварга тогооч” шалгаруулах ур чадварын уралдаан, сургалт зохион байгуулах	<p>Үндэсний уламжлалт болон орон нутгийн онцлог бүхий хоол, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх ажлын хүрээнд Сайнцагаан суманд үйл ажиллагаа явуулж буй Өргөө зоогийн газар, “Өндөр ээж хоол”-ны газар нь говь нутгийн уламжлал бүхий Хярамцагтай гурилтай шөл, Таван цулын шөл, Гүзээний салат, гэх мэт 3-4 нэр төрлийн хоол, цай ундааг хоолны цэсэндээ оруулж захиалгаар үйлчилж байна.</p> <p>11 дүгээр сард МСҮТ-ийн тогооч мэргэжлийн ангийн сурагчдын дунд ур чадварын уралдааныг зохион байгуулж нийт 17 оюутан оролцож ур чадвараа сорьлоо. Мөн хоол үйлдвэрлэл үйлчилгээний чанар стандартын хэрэгжилт, бодлого зорилтын талаар мэдээлэл зөвлөгөө, зөвлөмж өглөө.</p>	100

			<p>Мөн хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт дэвшилтэт технологи нэвтрүүлэх нь зөвлөлдөх уулзалтын хүрээнд мэргэжлийн тогооч, зөөгч нарын ур чадвар чадамжийг дээшлүүлэх, үндэсний брэнд хоол, үйлчилгээ, харилцан туршлага солилцох зорилготой Говийн бүсийн ур аварга тогооч, зөөгч шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан Өмнөговь аймагт болж өнгөрлөө. Тэмцээнд нийт 8 тогооч 1 зөөгч оролцож алт -3, мөнгө -3, хүрэл -4, тусгай байр 1 тус тус хүртсэн амжилтыг гаргалаа.</p>	
<p>3. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/119, А/355 тушаалыг хэрэгжүүлж ажиллах</p>	<p>Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” ажлын төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэх</p>	<p>“Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээний ажлын төлөвлөгөөг Аймгийн Засаг даргын захирамжаар батлуулах, төлөвлөгөөг 90 хувьтай хэрэгжүүлэн</p>	<p>Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулах ажлын хэсгийг АЗДаргын 2019 оны А/48 дугаар захирамжаар байгуулан төлөвлөгөө гарган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу нээлтийн арга хэмжээ, давс багатай хоол, хүнсийг хэрхэн үйлдвэрлэх талаар сургалт мэдээллийг Аймгийн ЗДТГазар, СТХЗХэлтэс, Сайнцагаан сумын ЗДТГазар, Монголын тогооч нарын холбооны аймаг дахь салбар зөвлөл зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулсан. Сургалтыг Монголын тогооч нарын холбооны дэд дарга Доктор Нарангэрэл багш хийсэн. Сургалтад Сайнцагаан сумын сургууль цэцэрлэгийн захирал эрхлэгч, тогооч нийт 52 хүн хамруулж 7 нэр төрлийн гарын авлага материалыг хүргэлээ.</p> <p>Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье аяны II шатанд хоолны давс бууруулах хяналт шинжилгээнд Сайнцагаан</p>	70

			<p>сумын СӨБ-4, сургууль-2, эмнэлэг-1, нийтийн хоолны 3 газар оролцож нийт 27 бүтээгдэхүүний давсны хэмжээг бууруулан, мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн баталгаажуулаад байна. Аяны хүрээнд хүнс, хоол үйлдвэрлэлийн газрууд бүтээгдэхүүнийхээ дээжийг итгэмжлэгдсэн лабораторид 80 хувь нь 2 удаагийн давтамжтай хамруулсан. Эхний шинжилгээгээр нийт хоолны найрлага дахь давсны хэмжээ 40 хувь, 2 дахь Аяны хүрээнд хүнс, хоол үйлдвэрлэлийн газрууд бүтээгдэхүүнийхээ дээжийг итгэмжлэгдсэн лабораторид 80 хувь нь 2 удаагийн давтамжтай хамруулсан. Эхний шинжилгээгээр нийт хоолны найрлага дахь давсны хэмжээ 40 хувь, 2 дахь удаагийн шинжилгээгээр 10 хувь буюу 30 хувийн үзүүлэлтээр бууруулж, жор технологийн 85 хувийг шинэчилж, технологийн картанд давсны хэмжээг тусган ажилласан нь энэхүү арга хэмжээний үр дүн юм.</p> <p>Дээрх арга хэмжээнд оролцсон ААНэгж байгууллагуудын 78 хувь нь нийгмийн хариуцлагын хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэглэгчдийн хоол хүнс, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, зөв зохистой хэрэглэх мэдлэг, мэдээлэл олгох сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах төлөвлөгөөг гаргаж мөрдөж ажилласан байна.</p>
--	--	--	---

			<p>Эмнэлэг, сургууль, цэцэрлэг, нийтийн хоолны газрууд нь мэдээллийн самбарт давс багатай бүтээгдэхүүний ач холбогдол, давсны хор уршиг, давсны хэрэглээг бууруулах сургалт сурталчилгааг хийж аяны явцын талаархи гарын авлага мэдээллийг хүүхэд, эцэг эх, үйлчлүүлэгчдэд хүргэн ажилласан.</p> <p>Мандал ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн хоолны нэр төрөл, технологийг шинэчлэн лабораториор шинжлүүлэн баталгаажуулах багш, ажилчид, эцэг, эх, сурагчдад давс багатай бүтээгдэхүүний талаар 2-3 удаа 800 орчим хүнд сургалт, мэдээлэл өгч идэвхитэй саначлагатай сайн оролцсон тул “Давс багатай хоол үйлдвэрлэл” номинацид нэрийг дэвшүүлж холбогдох материалыг ХХААХҮЯ-нд хүргүүлээд байна.</p>	
4. Засгийн газрын 223 дугаар тогтоолоор батлагдсан “Жимс, жимсгэнэ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Жимс, жимсгэнэ дэд хөтөлбөр боловсруулан батлуулж, 2019 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Дэд хөтөлбөр батлуулан 90-ээс дээш хувьтай хэрэгжүүлнэ.	<p>ИТХ-ын 2019 оны А/25 дугаар тогтоолоор “Жимс жимсгэнэ” дэд хөтөлбөрийг батлуулсан. Дэд хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүллээ. Хэрэгжилт 90%-тай.</p> <p>ХХААХҮЯамнаас ирүүлсэн “Жимсний суулгац зээлээр олгох” төслийн зар мэдээллийг аймгийн Ард телевиз, АСЦогцолбор, байгууллагын веб сайтуудад байршуулан мэдээлж сумдын холбогдох албан тушаалтангуудад албан тоот хүргүүлсний үр дүнд дээрх төсөлд 6 иргэнийг хамруулан чацарганы 520 ш, бэсрэг алим 107ш-ийг суулгацыг олгуулан тариалалт хийлээ.</p>	100

			 <p>2019 онд шинээр жимс жимсгэнийн тариалалт 4,4 га -аар нэмэгдэж, ургац 8,7 тн-ыг хураан авсан нь өмнөх оноос тариалсан талбай 1,2 га, хураан авсан ургац 6,4 тн-оор тус тус өссөн үзүүлэлттэй байна. Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хүрээнд “Жимс, жимсгэнийн тариалалт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт” зөвлөгөөнд 12 тариаланчыг төлөөлөгчөөр оролцуулж мэдлэг олголоо.</p> 	
<p>5. Засгийн газрын 278 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний ногоо” хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p>	<p>Хүнсний ногоо дэд хөтөлбөр боловсруулан батлуулж, 2019 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх</p>	<p>Дэд хөтөлбөр батлуулан 90-ээс дээш хувьтай хэрэгжүүлнэ.</p>	<p>Аймгийн ИТХ-ын 2019 оны А/25 дугаар тогтоолоор “Хүнсний ногоо” аймгийн дэд хөтөлбөрийг батлуулж 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүллээ.</p> <p>“Хүнсний ногоо” хөтөлбөрийн 1,5 сая төгрөгийн өртөг бүхий төмс, хүнсний ногооны 7 нэр төрлийн 534,5 кг үрийг 15 сумдын тариаланчдад үнэ төлбөргүй, 378,000 мянган төгрөгийн үнэ бүхий 6*20 хэмжээтэй хүлэмжний нийлэг хальсан хучлагийг 50 хувийн хөнгөлөлттэй 10 иргэнд тус тус</p>	<p>100</p>

олгосны **үр дүнд** төмс 0,3 га-гаас 1,5 тн, хүнсний ногоо 1 га-аас 15 тн-ийг хураан авсан.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас зээлээр олгосон 4x8 хэмжээтэй 4 ширхэг хүлэмжийг Цагаандэлгэр, Сайнцагаан, Дэрэн, Дэлгэрцогт сумдын ногоочдод захиалгаар нийлүүлсний **үр дүнд** тариалсан талбай шинээр 128 м<sup>2</sup> талбай, хураан авсан ургац 3,3 тн-оор нэмэгдээд байна.




Сайнцагаан, Цагаандэлгэр, Гурвансайхан, Луус сумын СХСангаас 16 иргэнд нийт 109 сая төгрөгийн зээл олгосноор шинэ ажлын байрын тоог 10-аар нэмэгдүүлсэн байна.

Аймгийн Хөдөлмөр Халамж үйлчилгээний газраас ажлын байраар хангах хөтөлбөрийн хүрээнд 10 иргэнийг 1 бүлгийн зохион байгуулалтад оруулан ажиллуулж 60м<sup>2</sup> талбай бүхий хүлэмж, төмсний үр 200 кг, хүнсний ногооны үр 0,5 кг, 240 ш үрсэлгээ болон шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласны **үр дүнд** төмс 0,5 тн, хүнсний ногоо 1,5 тн-ыг хураан авсан.

2019 онд аймгийн хэмжээнд төмс 21,4 га-аас 208 тн, хүнсний ногоо 13,3 га-гаас 118 тн ургац хураан авснаар хүн



			<p>амын хэрэгцээт хүнсний ногооны 15 хувийг хангаж байна.</p>  <p>Аймгийн хэмжээнд өргөст хэмх, лооль, чинжүү, амтат-гуа, тарвас зэрэг 20000 ш үрсэлгээг ногоочдод нийлүүлсэн ба төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах технологийн мэдлэг олгох гарын авлага материал бэлтгэн тариаланчдад хүргэн ажилласан.</p>	
6. Аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/581 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх	Аймгийн аварга тариаланч шалгаруулах журмын дагуу аварга тариаланч шалгаруулах	Аймгийн аварга тариаланч шалгаруулах материалыг хүлээн авч аймгийн засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шалгаруулсан байна.	Аймгийн аварга тариаланч шалгаруулах журмыг боловсруулан Аймгий Засаг даргын 2018 оны А/581 дугаар захирамжаар батлууллаа. 2019 оны 1 дүгээр сард Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр “Аймгийн тэргүүний тариаланч”-аар Сайнцагаан сумын 7-р багийн ахмад тариаланч Р.Мужилыг шалгаруулан алдаршууллаа.	100
7. Тариалангийн тухай хуулийг сурталчилах	Тариалангийн тухай хуулийг сурталчилах, тариалан эрхлэдэг иргэдэд сургалт зохион байгуулах	Газар тариалангийн чиглэлээр 2 удаагийн сургалт зохион байгуулж 80 хүнийг хамруулж мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн байна.	“Ургамлын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүнд батлагдсан гарал үүслийн гэрчилгээ олгох, сурталчлан таниулах” зорилгоор ХААТасгийн 15 мэргэжилтэн болон АС цогцолбороор 2 удаагийн сургалт хийсэн. Сайнцагаан сум, МХГазартай хамтран өрхийн тариалан эрхлэгчдийн мэдлэгийг нэмэгдүүлэхээр 25 тариалан эрхлэгчдэд гарал үүслийн гэрчилгээ олгох тухай сургалтыг явуулж, гарын авлага зөвлөмжөөр хангасан. Хүнсний ногоог зах зээлд худалдан	100

			<p>борлуулж буй 5 сумын 19 иргэнд гарал үүслийн гэрчилгээ олгож тайланг ХХААХҮЯамны ГТХБЗГазарт цахим шуудангаар хүргүүлж ажилласан. Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд учруулсан хохирлыг тооцох аргачлалыг 15 сумын ХААТасгийн мэргэжилтэнүүд болон 80 малчид тариаланчдад АС цогцолборт мэдээ мэдээлэл хүргүүлж ажиллалаа.</p>	
8. Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн хүрээнд тус аймагт байгуулах үйлдвэрүүдийг дэмжих	ЖДҮХСангаас 2-оос доошгүй үйлдвэрт санхүүгийн дэмжлэг үзүүлж, явцын мэдээг хугацаанд нь хүргүүлнэ.	<p>Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай байгуулах гэрээнд сум бүр жижиг дунд үйлдвэр шинээр байгуулж ажлын байрын тоог нэмэгдүүлж ажиллахыг тусгасан. Шинээр байгуулах, үйлдвэрлэлээ өргөтгөхөөр санал ирүүлсэн мах, махан бүтээгдэхүүн, ингэний сүүн бүтээгдэхүүн, тэмээний ноосон бүтээгдэхүүн талх нарийн боовны үйлдвэр, цехүүдэд дараах дэмжлэгийг үзүүлээд байна. Сайнцагаан, Эрдэнэдалай, Гурвансайхан, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Баянжаргалан сумдад 568.8 сая төгрөг /Орон нутгийн дэмжлэг 193.0, хувийн хөрөнгө оруулалт 323.6, төсөл хөтөлбөр 53,2/-ийн өртөг бүхий 11 үйлдвэр шинээр байгуулагдаж байнгын ажлын байр 21, түр ажлын байр 38 бий болсоны нэг нь орон нутгийн асфальтын зах зээлийг дангаараа хангах бүрэн боломжтой асфальт-бетон зуурмагийн үйлдвэр юм. Уг үйлдвэрийн газрын асуудлыг шийдвэрлэн олгосноор 80,0 сая</p>	100

			<p>төгрөгийн хувийн хөрөнгө оруулалтаар ашиглалтанд оруулан асфальт-бетон зуурмаг үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд цагт 100 тонн асфальт-бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай юм.</p> <p>Сайнцагаан сумын “Ноён Шанхай” ХХК аймгийн төвөөс 5км-т 1га газрыг шийдвэрлээд байна.</p> <p>ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар 45 иргэн, ААН-ийн төслийг хүлээн авч журмын дагуу хэлэлцэн эхний 10-т эрэмбэлэгдсэн 1,0 тэрбум төгрөгийн төслийг шалгарууллаа. Шалгарсан төслүүдийг батлагдсан эрэмбэ, дарааллаар судалж, шаардлага хангасан төслийг санхүүжүүлж ажиллахыг анхааруулсан аймгийн Засаг даргын албан тоот, А/264 захирамж, жижиг дунд үйлдвэрлэлийн төсөл шалгаруулах дэд хорооноос сонгон шалгаруулсан төслийн жагсаалтыг арилжааны банкуудад хүргүүлж 5 төслийн 420,0 сая төгрөг зээлдэгчдээ очиж 5 төсөл судалгааны явцдаа байна.</p>	
9. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.7 дахь заалтыг хэрэгжүүлэх	Төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх	Төрийн худалдан авалтад орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх ажлыг Худалдан авах ажиллагааны албатай хамтран зохион байгуулна.	<p>“Бүтээн байгуулалт, иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд орон нутгийн төр, хувийн хэвшлийн байгууллагуудын харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой “Эх оронч худалдан авалт, орон нутгийн үзэсгэлэн худалдаа-2019” арга хэмжээг 5 дугаар сарын 2-ны өдөр ХХААГ, ХХҮГ, БСУГ, МХАҮТ-ын салбар, Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо, Элгэмсэг</p>	70

		<p>Дотно Дундговь ТББ-тай хамтран зохион байгууллаа.</p> <p>Үзэсгэлэн худалдаанд 37 иргэн, ААНэгж оролцож нийт 5,5 сая төгрөгний борлуулалт хийсэн байна. Үзэсгэлэнгийн төгсгөлд төр хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх хамтран ажиллах хэлэлцүүлэг болж 15 сумын 70 гаруй иргэн аж ахуйн нэгжийн төлөөлөл санал бодлоо солилцон бүтээгдэхүүн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх төрийн худалдан авалтад нийлүүлэх боломж, нөөцийн талаар ярилцлаа.</p> <p>Дотоодын үйлдвэрлэл эрхлэгч иргэн ААНэгжээс аймгийн хэмжээнд мах, сүү гэх мэт 50 гаруй нэр төрлийн 1,582,4 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлсэн байгаа нь <b>өмнөх</b> оноос хэдэн хувиар 13,7 хувиар өссөн байна.</p> <p>Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, зах зээлд таниулах, бүтээгдэхүүний нэр төрөл борлуулалтыг өргөжүүлэх, зорилго бүхий “Дундговьд үйлдвэрлэв” дэлгүүр 2019 оны эхний 11 сарын байдлаар 201 иргэн, 3 ААНэгжийн 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг хүлээн авч 92,0 сая төгрөгийн борлуулалттай ажилласан нь өмнөх оноос 35 хувиар өссөн байна. Эрдэнэдалай сумын Кашмердалай цех нь ноолуур, хонь, тэмээний ноосон төрөл бүрийн өвөрмөц шинж чанартай инноваци шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоод гадаадын зах зээлийн хэрэглэгчдэд</p>
--	--	--



			<p>нийлүүлдэг. Тус цехийн үйлдвэрлэсэн тэмээний ноосон хөнжил “Аймгийн брэнд” бүтээгдэхүүн болсон төдийгүй гадаад дотоодын зах зээлд эрэлт ихтэй бүтээгдэхүүн болжээ. Кашмер далай цех нь 2019 онд 6 нэр төрлийн 2245 тооны бүтээгдэхүүн үйлдвэрлэж 8 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. Тус цех нь нийт 4 ажилтантай. Дотоодод үйлдвэрлэсэн үндэсний бараа, бүтээгдэхүүнийг худалдан авалтаар дэмжих зорилгоор Аймгийн Засаг даргын санаачлагаар тус үйлдвэрийн үйлдвэрлэсэн тэмээний ноосон улавчийг бэлгийн багцдаа худалдан авахаар гэрээлэн 2019 онд 1,187,000 төгрөгийн 237 ширхэг улавчийг нийлүүлсэн байна.</p>	
<p>10. Засгийн газрын 2016 оны 287 тогтоол “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах</p>	<p>Аймгийн хэмжээнд “Хөх сав, канистергүй аймаг, сум хөдөлгөөн өрнүүлэх, Хөх савны хор хөнөөлийг сурталчилах</p>	<p>Аймгийн хэмжээнд “Хөх сав, канистергүй аймаг, сум хөдөлгөөн өрнүүлэх, Хөх савны хор хөнөөлийг сурталчлах ажлуудыг эрчимжүүлэх, -Уламжлалт сав баглааны үйлдвэрлэлийг бий болгох хүсэлт ирүүлсэн иргэн, ААН-ийн санал, санаачлагыг дэмжих</p>	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүнсний аюулгүй савны талаарх мэдээлэл, зөвлөмжийг сургууль, цэцэрлэг, хоол хүнс үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж нийт 20 гаруй байгууллагын ажлын байранд дээр өгч 100 гаруй гарын авлага материалаар ханган ажиллалаа. МХГ, БОАЖГ, СХХэлтэс Сайнцагаан сумын ЗДТГазартай хамтран Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолоор “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох” тухай тогтооыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, иргэдэд сургалт зохион байгууллаа. Сургалтанд нийт 52 иргэн аж ахуй нэгж хамрагдаж Нийлэг хальсан уутны хор хөнөөл, стандарт,</p>	<p>100</p>

			<p>худалдаа үйлчилгээнд хэрэглэгдэж буй зарим нийлэг хальсан уутны хэрэглээний талаарх мэдээллүүдийг хүргэлээ.</p> <p>Мөн сумдууд багийн нийтийн хурал, Малчдын зөвлөгөөн арга хэмжээнүүдэд хамрагдсан нийт 600 орчим малчин иргэдэд Хөх сав канистергүй сум болох аяны талаар, “Хуванцар савны хор хөнөөл, “зориулалтын савны тэмдэг, тэмдэглэгээ”-ний талаарх сургалт, мэдээлэл, гарын авлага зэргийг өгч ажилласан.</p> <p>2018 онд ЖДҮХС-аас “Эко модон сав үйлдвэрлэл” төслөөр зээлийн дэмжлэгт хамрагдаж үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа өргөтгөн айраг, хоормог, ус хийдэг том хувин, мал саадаг саалийн хувин, айраг, хоормогны сөнгийн хувин, бүрхээр, дээж өргөдөг жижиг хувин, дээжийн халбага гэх мэт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж төрлөө олшруулснаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо 2017 оноос 2-3 дахин өсч Дундговь, Баянхонгор, Өмнөговь, Улаанбаатар хотод борлуулалтын цэгээ нээжээ.</p> <p>Үйлдвэрлэлээ эрчимжүүлж, ажлын байр нэмэгдүүлж, бизнесээ өргөжүүлэхээр ЖДҮХС-аас авсан урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг зориулалтынх нь дагуу, санхүүгийн сахилга баттайгаар зарцуулж, гэрээгээр хүлээсэн үүргээ сайн биелүүлсэн улсын хэмжээний нийт 7 аж ахуй нэгжийн нэгээр ТЭББЭ ХХК шалгарч ХХААХҮ-ийн Сайдын санаачилгаар Найдвартай</p>
--	--	--	---

			зээлдэгчдээ талархал илэрхийлж олгосон "Сайн зээлдэгч" өргөмжлөлийг гардан авсан байна. Мөн Өмнөговь аймгийн "Говь фестивал-2019" үзэсгэлэн худалдааны "Шилдэг үйлдвэрлэгч" номинацийн эзэн болжээ. 2019 онд 100 гаруй сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 64 сая төгрөгийн борлуулалт хийсэн ба 40 гаруй сая төгрөгийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нөөцтэй байна.	
11. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.5 дахь заалтыг хэрэгжүүлэх	-“Дундговь түншлэл-2019” арга хэмжээг зохион байгуулах -“Явуулын ахуй үйлчилгээ” арга хэмжээг 1 суманд зохион байгуулах	-“Дундговь түншлэл-2019” арга хэмжээний оролцогчидын тоо болон борлуулалтын орлого өссөн байна. -“Явуулын ахуй үйлчилгээ” 1 суманд зохион байгуулж иргэдэд үйлчилсэн байна.	Аймгийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэрлэл эрхлэгчид, малчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, худалдан борлуулах зорилгоор “Дундговь Түншлэл-2019” үзэсгэлэн худалдааг Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон Ажил олгогч эздийн холбооны Дундговь аймаг дахь салбар хамтран 2019 оны 9 дүгээр сарын 20, 21-ны өдрүүдэд 15 дахь жилдээ амжилттай зохион байгуулллаа. Үзэсгэлэн худалдаанд өөрийн аймгийн 15 сум, Улаанбаатар, Сэлэнгэ, Төв аймгийн 130 гаруй үйлдвэрлэгчид оролцож 54,2 сая төгрөгийн борлуулалт хийж өмнөх онтой харьцуулахад оролцогчийн тоо 6,9, борлуулалт 1,1 хувиар тус тус өссөн байна. 2019 оны 05 сард Говь-Угтаал суманд үсчин, гоо сайхан, маникюр, гуталчин, алт мөнгөний дархан, гэр	

			<p>ахуйн цахилгаан засварын үйлчилгээгээр нийт 188 иргэнд үйлчилж 2,8 сая төгрөгийн орлоготой ажиллаж борлуулалтын орлого өмнөх оныхоос 0,6 сая төгрөгөөр өссөн байна.</p> <p>Монголын үсчин гоо сайханчдын холбоотой хамтарсан үсчин гоо сайханчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, үсчдийн үзүүлэх тоглолтыг зохион байгуулж 18 үсчин гоо сайханч оролцож мэргэжлийн зэрэг мэдлэг ур чадвараа ахиуллаа. 2019 оны 12 дугаар сарын 08 ны өдөр үсчин гоо засалч, хумс дизайн урлалын “ҮСЧИН, ГОО САЙХАН-2019” тэмцээнийг Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгууллаа. Тэмцээн 8 төрлөөр явагдаж нийт 20 үсчин гоо сайханч мэргэжлийн ур чадвараа сорьлоо. Монгол улсын үсчин, гоо засалчдын холбооны тэргүүн ОУ-ын шүүгч Цогзолмаа, Үйлдвэрлэл урлалын коллежийн гоо сайханы тэргүүлэх зэрэгтэй багш Дарьжав нар шүүж дүгнэсний эцэст үсчин гоо сайханчдын ур чадвар дээшилж улс бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцох ур чадварыг эзэмшсэн байгааг онцлон дурьдлаа.</p>	
12. Аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/524 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх	“Нэг суурин - Нэг бахархал” аяныг өрнүүлэх	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, сургалт зохион байгуулах, түүнийг хэрэглэгчдэд хүргэх борлуулалтын сүлжээг бий болгосон байна. Орон нутагт үйлдвэрлэсэн	ХХАХҮЯ-аас орон нутгийн нөөц баялаг, түүхий эдийг зүй зохистой ашиглан соёл, уламжлалыг хадгалсан, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэн, импорт орлохуйц экспортын барааны	100




		<p>бүтээгдэхүүнийг патентжуулах ажлыг эхлүүлсэн байна.</p>	<p>нэр төрлийг олшруулж, Монгол брэнд бүтээгдэхүүнийг дэлхий нийтэд сурталчлах, таниулах зорилгоор “Нэг суурин-Нэг бахархал” аяныг жилийн хугацаатай зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу аймгийн хэмжээнд аяныг хэрэгжүүлэх ажлын хэсгийг аймгийн ЗД-ын захирамжаар батлуулсан. Аяны хүрээнд үйлдвэр эрхлэгчдэд бизнес арга зүйн сургалт зөвлөгөөг 8 удаа зохион байгуулж нийт бизнесийг давхардсан тоогоор 150 бизнесменийг хамрууллаа.</p>  <p>Мөн “Дундговьд үйлдвэрлэв” сэтгүүлийг гаргахаар Эрс тэс дизиан ХХК-тай 3,750,000 төгрөгийн гэрээг байгуулан ажлын явц 70 хувьтай байна. Сэтгүүлд 15 сумын 150 бизнес эрхлэгчийг хамруулахаар төлөвлөсөн ба зураг авалт 70 хувьтай байна.</p> 	
<p>13. Засгийн газрын тогтоол</p>	<p>Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулах, аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлэх</p>	<p>Аймгийн мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг 85 дээш хувиар, аюулгүй нөөцийг 80-аас доошгүй хувиар ханган биелүүлсэн байна.</p>	<p>2019-2020 оны мал аж ахуйн салбарын өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангалтын дүнгээр аюулгүй нөөц бүрдүүлэлт: Сумдын Засаг даргын аюулгүй нөөцөд өвс- 600тн, тэжээл-267,3 тн, аймгийн аюулгүй нөөцөд-230 тн өвс 45 тн тэжээлийн нөөцтэй буюу сумын</p>	<p>100</p>

			<p>хэмжээний аюулгүй нөөц бүрдүүлэлтийн дундаж өвс-100% тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэлт-59,4 хувиар өвс тэжээлийн дундаж 79,7 хувиар аймгийн аюулгүй нөөц 143,1 хувьтай байгаа ба нийт дүнгээр 88,7 хувиар бүрдүүлсэн.</p> <p>ХХААХҮЯ-ийн Сайдын 2016 оны А/71 дүгээр тушаалаар баталсан Мал аж ахуй өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх зааврын дагуу гаргадаг 10 хүснэгт үзүүлэлтийг сумдаар нэгтгэхэд малчдын өвс тэжээл татан авалт-23,3%, хашаа хороогоо засч тохижуулсан, ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн-93,5%, хоол хүнс, дулаан хувцасны хангалт-99,3%, түлээ,түлшний нөөц-95,5%, хүн мал эмнэлэгийн эмийн сан-93%, мал эмнэлэгийн арга хэмжээ-92,8%-тай хангагдаж нийт малчин өрхийн өвөлжилтийн бэлтгэл-84,6%-тай, аймгийн хэмжээний бэлтгэл хангасан дүнгээр малчдын өвс тэжээл татан авалт-23,3%, аймгийн аюулгүй нөөц бэлтгэл-100%, сумдын аюулгүй нөөц бэлтгэл-79,7 %, худгийн бэлэн байдал-98,4%, малын усан хангамж-97%, малчин өрхийн хашаа бууцны хангамж-97%-иар өвөлжилтийн бэлтгэлээ хангаж 2019 оны аймгийн хэмжээний өвөлжилтийн бэлтгэл хангалт 82,8 хувьтай хангагдсан.</p> <p>Дундговь аймгийн дүнгээр 2019-2020 оны өвөл хавар 57 багт 7573 малчин өрх 4 сая толгой малнаас 41435 тэмээ, 171244 адуу, 79409 үхэр, 1943479 хонь, 1802849 ямаа толгой буюу хонин толгойд шилжүүлснээр</p>	
--	--	--	--	--

			5,4 сая толгой мал өвөлжиж, хаваржих юм.	
14. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.35 дахь заалтыг хэрэгжүүлэх	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх	Бэлчээрийн усан хангамжийг өмнөх оноос 2-оос доошгүй хувиар нэмэгдүүлсэн байна	Төсөл хөтөлбөрийн шугамаар: - Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Дэлгэрцогт сумдад 33БЭУХөгжил төслийн шугамаар 5 гүн өрмийн худаг 90 сая төгрөгөөр, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 5 суманд гүн өрмийн 5 худгийг 125 сая төгрөгөөр, ОНХС-ийн хөрөнгөөр: - Өлзийт сум 1 гүн өрмийн худаг, 6 сум 30 энгийн уурхайн худгийг 55,6 сая төгрөгний зардлаар худаг засварлаж, нийт 289,6 сая төгрөгийн санхүүжилтээр бэлчээр усжуулах ажил хийгдсэн. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 15 сумын 41 цэгт усны геофизикийн хайгуулыг тендерт шалгарсан Эрдэнэдринлинг ХХК бүрэн гүйцэтгэсэн. - “Уур амьсгалд ухаалаг хандлага бий болгох нь” төслийн санхүүжилтээр Луус сумын Суврага багийн 7 малчин өрхийг бүлгийн зохион байгуулалтанд оруулж 1 гүн өрмийн худаг шинээр гарган сэргээгдэх эрчим хүчийг суурилуулан 2 га бэлчээрийн талбайд малын тэжээлийн ургамал тариалсан. Усан хангамж өмнөх оноос 1,8 хувиар нэмэгдсэн.	100
15. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.36 дахь заалтыг хэрэгжүүлэх	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулах.	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг 40 мян.га-аас доошгүй талбайд, 80-аас доошгүй хувийн техникийн үр дүнтэй гүйцэтгэнэ.	Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготной нийт 45 мян/га бэлчээрийн талбайд энгийн механик болон микробиологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгуулсан. Тус аймагт зохион байгуулагдсан гамшгаас хамгаалах команд штабын сургалтаар мэргэжлийн анги албадын	100

			<p>бие бүрэлдэхүүн нийт 303 хүний бүрэлдэхүүнтэйгээр Дэрэн сумын Алаг-Өндөр багийн нутагт 25 мян/га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар, 10 сумын 20 мян/га талбайд 40 тн бактержуулсан бэлдмэл цацаж улсын төсвөөс нийт 237,7 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>ХХААХҮСайдын 2019 оны 9 сарын 9-ний өдрийн А/303 дугаар тушаалаар 50,0 мян.га бэлчээрийн талбайд хортон мэргэчтэй тэмцэхээр болоод байна.</p> 	
<p>16. ХХААХҮЯ-ны сайдын 2017 оны А/71 тушаалыг хэрэгжүүлэх</p>	<p>5 төрлийн малд үзлэг ангилалт хийж анги, чанарыг тогтооно.</p>	<p>13000-аас доошгүй хээлтэгч, хээлтүүлэгч малд үзлэг ангилалт хийж анги чанарыг тогтоосон байна.</p>	<p>Аймгийн Засаг даргын 2019 оны 05 сарын 08 өдрийн А-198 тоот захирамжаар батлагдсан ажлын хэсэг Өндөршил сумын 3000 адуу, Олдохын хүрэн бор 3000 тэмээ, Сайнцагаан сумын 20000 хонинд хаврын хувьсын ангилалтыг хийж гүйцэтгэсэн. Сайнцагаан, Хулд, Эрдэнэдалай сумдын цөм сүрэг бүхий 29 айл өрхүүдээс өсвөр хээлтүүлэгч 70 шилж сонгон бойжуулсан.</p> 	<p>100</p>

				
17. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.25 дахь заалтыг хэрэгжүүлэх	Дундговь аймгийн мал зүйч, үржүүлэгчдийн холбооны шийдвэрээр загвар ҮҮНэгжүүдийг баталгаажуулна.	Аймгийн хэмжээнд 3-аас доошгүй ҮҮНэгж шинээр байгуулж үйл ажиллагааг эхлүүлсэн байна	Сайнцагаан сумын "Уудам жаргалант", Луус сумын "Тойрмын ус" ХХК-иуд мал үржлийн үйлчилгээний нэгж шинээр байгуулж, Эрдэнэдалай суманд үржлийн аж ахуйн нэгжийг ахмад мал зүйч нар хамтран тус тус байгуулан тухайн чиглэлийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.	100
18. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.33 дахь заалтыг хэрэгжүүлэх	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	Аймгийн хэмжээнд үржилд ашиглаж буй нийт хуц, ухныг хээлтүүлгийн бус үед эх сүргээс 80-аас доошгүй хувиар ялгана.	Аймгийн хэмжээнд ялгавал зохих хуцны 75 хувь буюу 8674 хээлтүүлэгч, уханы 73 хувь буюу 6749 хээлтүүлэгчийг тус тус ялган суурилсан. Аймгийн хэмжээнд "Хулд таван эрдэнэ", "Адаацаг ажнай" ХХК 2 аж ахуй нэгжид бог малын хээлтүүлэгчийг ялган суурилоод байна. Сайнцагаан суманд мал үржлийн үйл ажиллагаа явуулах "Уудам жаргалант" ХХК хувийн хэвшлийн нэгжид 50 хурган хуцыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр олгож үйл ажиллагааг дэмжиж ажиллалаа.	100
19. Засгийн газрын үйл ажиллагааны	Үржлийн ажлын ололтыг хянан магадлан	Өндөршил сумын "Шилийн" адуу,		ХХААХҮЯамны сайдын 2019 оны 04 сарын 15-ны өдрийн А/108 дугаар

хөтөлбөрийн 2.33 дахь заалтыг хэрэгжүүлэх	баталгаажуулж, шинэ омгийн малтай болох	Сайнцагаан хонийг баталгаажуулж болсон байна.	сумын хянан омог тушаалаар Өндөршил адуунд хянан магадлагаа хийх ажлын хэсгийг,  ХХААХҮЯамны сайдын 04 дүгээр сарын 04 өдрийн А/93 дугаар тушаалаар хонины хянан магадлагааны ажлын хэсэг тус тус томилогдож хувиарын дагуу хаврын үзлэг ангилалтыг хийж гүйцэтгэсэн. 2019 оны 11 сарын 20 өдрийн ХХААХҮ-яамны сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж “Өндөршил адуу”, 2019 оны 12 сарын 10-ны өдрийн ХХААХҮСайдын зөвлөлийн хурлаар “Сайнцагаан хонь”-ыг тус тус омог болгон баталгаажууллаа.	100
<b>Нийт арга хэмжээ-19. Үүнээс 100 хувьтай 17, 70 хувьтай 2</b>				<b>96,84%</b>

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА:                      О.БАТ-ЭРДЭНЭ

ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН                      О.ГАНЦЭЦЭГ

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА                      Н.ЭРДЭНЭ-ОЧИР